



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 150

Дэлгэрхаан сум

Сумын хэмжээнд 2026 онд байгаль хамгаалах
нөхөн сэргээх ажлуудад хяналт тавьж хүлээн
авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 сарын 19-ний 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалаар хийгдэж буй бусдаар гүйцэтгүүлэх бүх гэрээт ажил арга хэмжээнд хяналт тавьж хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: У.Ариунтуяа

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ц.Золзаяа

(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Соёлмаа

(Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Л.Баатархүү

(Нярав)

Нарийн бичиг дарга

Х.Мөнхбат

(Байгаль хамгаалагч)

2.Гэрээний хавсралт болох ажлын даалгаврын дагуу ажлыг чанартай сайн зохион байгуулахыг төрийн бус байгууллагын тэргүүн, хийгдсэн ажлыг зургаар баталгаажуулж актаар хүлээн авахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2326010100

